Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандарт, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,720,404.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 319,401.7 мянган төгрөгөөр буюу 22.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Авлага	12,688.6	12,000.0	-688.6
Бараа материал	79,131.3	160,837.8	81,706.5
Үндсэн хөрөнгө	2,375,288.4	2,534,512.7	159,224.3
Хуримтлагдсан элэгдэл	-1,066,105.1	-986,945.6	79,159.5
Нийт хөрөнгө	1,401,003.2	1,720,404.9	319,401.7
Өр төлбөр	0.0	10,919.5	10,919.5
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,401,003.2	1,709,485.4	308,482.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,401,003.2	1,720,404.9	319,401.7

Авлага дансны үлдэгдэл 12,000.0 мянган төгрөг болж өмнөх оноос 688.6 мянган төгрөгөөр буурсан ба моторын авлага тусгагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 160,837.8 мянган төгрөг болж өмнөх оноос 81,706.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 78,741.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, бусад байгууллагаас 76,903.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 73,938.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,534,512.7 мянган төгрөг болж 159,224.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12,178.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, бусад байгууллагаас 465,430.5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 318,384.2 мянган төгрөгийн хөрөнгийг (аймгийн ИТХ-ын 2025.06.12-ны өдрийн 7/38 дугаар тогтоолоор 60,000.0 мянга, 7/42 дугаар тогтоолоор 258,384.2 мянга) акталсантай холбоотой байна.

Тайлант оны эцэст 10,919.5 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь 2025 оны 11, 12 дугаар сарын зардлын эрхийг Сангийн яам хааж гүйлгээ зогссоноос 14 иргэн, аж ахуй нэгжид 10,919.5 мянган өр төлбөртэй гарсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Өр төлбөрийн задаргаа

(мянган төгрөгөөр)

№	Байгууллага, иргэний нэр	Өр төлбөрийн дүн
1	"Монголын цахилгаан холбоо" ХХК	693.0
2	"Монгол шуудан" ХХК	254.0
3	С.Бадамдорж	1,000.0
4	"Жаргалант Богд" ХХК	2,360.2
5	Архивын тасаг	1240.0
6	Т.Уранчимэг	1,183.5
7	Газрын төлбөр	150.7
8	"Цогц мандах өглөө" ХХК	301.3
9	Б.Дэлгэрмаа	88.0
10	АТБӨЯХАТ	152.8
11	БУЯНЖАРГАЛ	1,672.0
12	"Цагаангуа" ХХК	1,010.0
13	Н.Норов	490.0
14	"Ирмүүн төгс хөгжил" ХХК	1,440.0
	Нийт дүн	10,919.5

Эх сурвалж: Өглөгийн журнал

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 308,482.2 мянган төгрөгөөр өсөж 1,709,485.4 мянган төгрөг болсон байна.

Программ хангамжийн судалгаа

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн Аcolous программ, хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд "Лүэ" ХХК-ийн "ХХС-ийн программ"-ыг ашиглаж байна.

Тайлант онд "Санхүүгийн тооцоолох" ХХК-д 572.0 мянган төгрөгийг программын сунгалтад шилжүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,619,706.3 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4,200.0 мянга нийт 11,623,906.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 1,623,906.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1 удаа тодотгон 450,770.9 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс орон нутгийн төсвөөс 1,172,135.4 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга нийт 1,173,135.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,172,135.4 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга нийт 1,173,135.4 мянган санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,114,477.6 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,017.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж нийт 1,115,495.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл 1,085,313.9 мянган төгрөг буюу 92.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 30,181.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв					
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,173,135.4	1,085,313.9	87,821.5	92.5
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	804,536.3	746,552.0	57,984.3	92.8
1.2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	215,922.1	210,219.1	5,703.0	97.4
1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	38,192.0	34,092.0	4,100.0	89.3
1.4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	40,000.0	33,432.3	6,567.7	83.6
1.5	81549 Ахмадын сан	4,500.0	3,500.0	1,000.0	77.8
1.6	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	38,485.0	27,814.7	10,670.3	72.3
1.7	82212 Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах зардал	28,000.0	27,987.8	12.2	100.0
1.8	82310 Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	3,500.0	1,716.0	1,784.0	49.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 9,247.1 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоор 13,141.7 мянга нийт 22,388.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, гэрэл цахилгааны төлбөрт 1,071.3 мянга, шатахууны зардалд 815.0 мянга, багаж,

техник, хэрэгслийн зардалд 3,615.0 мянга, урсгал засварын зардалд 350.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 12,277.2 мянга, нийт 18,128.5 мянган төгрөгийг зарцуулж 4,260.3 мянган төгрөгийг орон нутагт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Ерөнхий чиглэлийн судалгаа

1. Бүтэц орон тоог аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 9, гүйцэтгэх 12, үйлчлэх 7, нийт 28 орон тоог баталсан бөгөөд тайлант оны эцэст удирдах 8, гүйцэтгэх 10, үйлчлэх 6, нийт 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

2. Сургалт, семинарын 3,736.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд тайлант онд 3 төрлийн сургалтыг зохин байгуулж 3,736.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сумын Засаг даргаар 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулж, төлөвлөгөөнд 354,113.7 мянган төгрөгийн 5 худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар, 115,438.8 мянган төгрөгийн 8 ажлыг шууд худалдан авахаар тусгасан байна.

Сумын ЗДТГ-т шатах тослох материал худалдан тендерийг 30,000.0 мянган төгрөгөөр харьцуулалтын аргаар зохион байгуулж, “Ник” ХХК шалгарч гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1а/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,316,736.1 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,316,736.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,167.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 8,558.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас хоол хүнс, цагаан идээний зардал 21.4 хувь буюу 7,153.4 мянга, бэлэг дурсгалд 14.9 хувь буюу 4,982.7 мянга, уралдаан тэмцээний шагнал, урамшуулалд 26.3 хувь буюу 8,800.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 180 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 174 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 6 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 14,417.3 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, аудитаар зөрчил илрээгүй:

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитыг Баянхонгор аймаг дахь ТАГ-ын аудитор Д.Эрдэнэбулган гүйцэтгэж нийт 18,813.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч, зөрчлийг арилгах, зөрчил давтан гаргахгүй байх 18,813.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлэн хэрэгжилтийг FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	13,813.0	1	13,813.0	100.0
Нийт дүн	1	13,813.0	1	13,813.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,680.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 1,680.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Автомашин акталж, данснаас хасах тухай” 7/38 дугаар тогтоолоор хөрөнгөд бүртгэлтэй 35,000.0 мянган төгрөгийн галын авто машиныг “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-т сэлбэгээр ашиглуулж актлах шийдвэр гарсан байхад бусад байгууллагад шилжүүлсэн гэсэн ангиллаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 800.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 800.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 800.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 12,715.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 11,915.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Сумын Засаг даргын 2025.02.27-ны өдрийн “Сумын нутгийн зөвлөлийн нэгдсэн золголт зохион байгуулж, зардал санхүүжүүлэх тухай” А/31 дүгээр захирамжаар 200.0 мянган төгрөгөөр монгол архи худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 200.0 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд оролцох тамирчдын тээврийн зардалд 600.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 600.0 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд орлогыг буруу тусган бүртгэсэн	1	1,680.0	-	-	1	1,680.0	1	1,680.0	-	-
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	35,000.0	-	-	1	35,000.0	1	35,000.0	-	-
Дүн	2	36,680.0	-	-	2	36,680.0	2	36,680.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Сумын Засаг даргын 2025.02.27-ны өдрийн "Сумын нутгийн зөвлөлийн нэгдсэн золголт зохион байгуулж, зардал санхүүжүүлэх тухай" А/31 дүгээр захирамжаар 200.0 мянган төгрөгөөр монгол архи худалдан авсан байна.	1	200.0	1	200.0	-	-	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд оролцох тамирчдын тээврийн зардалд 600.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-
Дүн	2	800.0	2	800.0	-	-	-	-	-	-



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 60/А0571121/БНА-2026/
012/НА-СТА-ТМЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн "Сумын нутгийн зөвлөлийн нэгдсэн золголт зохион байгуулж, зардал санхүүжүүлэх тухай" А/31 дүгээр захирамжаар 200,000 (хоёр зуун мянга) төгрөгөөр монгол архи худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7-т "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх¹.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Бурмаа, нягтлан бодогч З.Нанжидмаа нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:

6417743544

Б-ДА006-7 9007423

Н.БАТЧИМЭГ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

61/AOS71121/БНА-2026/
012/НА-СТА-ТНД

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд оролцох тамирчдын тээврийн зардалд 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг дарга, нягтлан бодогч нараар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх¹.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Бурмаа, нягтлан бодогч З.Нанжидмаа нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно